



2022
ХАГАС
ЖИЛИЙН
ТАЙЛАН



АГУУЛГА

- ТУЗ-ИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ
- ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ
- АЛСЫН ХАРАА, ҮНЭТ ЗҮЙЛС
- КОМПАНИЙН ТҮҮХЭН ТОВЧОО
- ШИНЭ БОЛОН ШИНЭЧЛЭГДСЭН БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД
- НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ЭЕРЭГ НӨЛӨӨ
- ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДЛУУД
- ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД
- ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ
- САНХҮҮГИЙН ТАЙЛАН МЭДЭЭЛЭЛ
- ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА УДИРДЛАГА
- МФС 2.0 ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА





ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГЫН МЭНДЧИЛГЭЭ

Эрүүл мэндийн хүнсний зах зээлийг Монгол Улсад хөгжүүлэх, цаашлаад эцсийн бүтээгдэхүүн экспортод гаргах бидний алсын хараанд итгэл хүлээлгэсэн хөрөнгө оруулагч, хэрэглэгч, харилцагч та бүхэндээ мэндчилж байна.

Монос Групп нь эм, гоо сайхны бүтээгдэхүүний импорт, борлуулалт үйлдвэрлэлийн 32 жилийн бизнесийн туршлагадаа тулгуурлан эрүүл мэндийн хүнсний зах зээлд нэвтрэхээр Монос Хүнс компанийг үүсгэн байгуулаад 10 жил болжээ. Анх Монос Группт төслийн менежерээр ажлын гараагаа эхлүүлж байхад санаачилсан Чацаргана төсөл маань бодит бүтээн байгуулалт болсон төдийгүй бизнес нь жилээс жилд өргөжин тэлж байгааг харахаар туйлын таатай байдаг бөгөөд цаашдын өсөлт хөгжилд чиглүүлэх хүндтэй үүргийг хүлээж Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар томилогдоод байна.

Мөн ТУЗ-ийн болон ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнд ч тодорхой өөрчлөлт орсон тухай мэдээллийг тухай бүрд танилцуулсан билээ.

Бид бүхэн Ковид цар тахлын дэгдэлттэй энэ хугацаанд импортлогч орны хүндрэл бэрхшээлийг хангалттай мэдэрсэн болов уу. Дан ганц өөрсдийн түүхий эдийг худалдаалах бус бидэнд байгаа хамгийн үнэтэй зүйл болох Монгол хүний оюуны сэтгэлгээний бүтээлийг нэмүү өртөг шингээн экспортлох нь бид бүгдийн алсын хараа гэдэгт бид итгэдэг. Энэ итгэл маань хөрөнгө оруулагч, хэрэглэгч, харилцагч цаашлаад улс эх орны өмнө хүлээсэн бидний эрхэм хариуцлага юм.

Монос Хүнс ХК-ийн 2022 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлангаа хувьцаа эзэмшигч та бүхэндээ хүргэж байна.

Манай нийгэм эдийн засагт үүсээд байгаа хил гааль, ачаа тээвэр, сав баглаа түүхий эдийн үнийн өсөлт, валютын хомсдол болон үнийн өсөлт, ажиллах хүчний хомсдолтой байдал зэрэг олон хүндрэл бэрхшээлтэй бид байнга нүүр тулгарч байгаа ч Монос Хүнс ХК нь борлуулалтаа өнгөрсөн оны мөн үеэс 85 хувиар, цэвэр ашгаа 176 хувиар өсгөсөн өндөр бүтээмжтэй ажиллажээ.

Түүнчлэн бидний хамгийн чухал зорилтын нэг болох MFC2.0 төсөл буюу одоогоор хоёр тусдаа байршилд үйл ажиллагаа явуулдаг эрүүл мэндийн шингэн хүнс болон хуурай хүнсний үйлдвэрүүдийг нэгтгэсэн цогц үйлдвэрийг барьж байгуулахаар бид хичээнгүйлэн ажиллаж байна.

Уг үйлдвэр ашиглалтад орсноор үйлдвэрийн хүчин чадлаа нэмэгдүүлэх, гар савлагааны процессыг автоматжуулж дотоодын зах зээлийн эрэлтийг бүрэн хангах, тасалдлыг арилгах төдийгүй сав баглаа боодолд ашиглагдаж буй хуванцрын болон цаасны хэрэглээг бууруулах шинэ стандартыг оруулж байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа явуулах олон давуу тал бий болно.

МОНГОЛ ОЮУН СЭТГЭЛГЭЭНД ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ХАМТРАН ЭЗЭМШИГЧ ТА БҮХЭНД АМЖИЛТЫН ДЭЭДИЙГ ХҮСЬЕ.

Х.Ананд
Монос Хүнс ХК-ийн ТУЗ-ийн дарга
Монос Группийн гүйцэтгэх захирал

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

ТУЗ-ИЙН ЕРДИЙН ГИШҮҮД



Х.Ананд

ТУЗ-ийн дарга
Монос Групп ХХК
Гүйцэтгэх захирал



Л.Хүрэлбаатар

ТУЗ-ийн гишүүн,
Хөдөлмөрийн баатар, доктор,
профессор, академич
Монос Групп ХХК Ерөнхийлөгч



Х.Солонго

ТУЗ-ийн гишүүн
Монос Косметик ХХК
ТУЗ-ийн дарга



Ц.Цэцэгбадам

ТУЗ-ийн гишүүн
Монос Групп ХХК
Санхүү эрхэлсэн захирал



А.Отгондарь

ТУЗ-ийн гишүүн
Монос Хүнс ХК
Гүйцэтгэх захирал



Ч.Баттогтох

ТУЗ-ийн гишүүн
АУ-ны доктор, дэд профессор
АШУИС-ийн тэнхимийн эрхлэгч

ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮД



Б.Гантулга

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Цалин урамшуулал, нэр дэвшүүлэх
хорооны дарга,
Ардын Тэтгэврийн Данс ХХК
Гүйцэтгэх захирал



О.Лхагвасүрэн

ТУЗ-ийн хараат бус гишүүн
Аудитын хорооны дарга,
Сэцэн Билгүүн ХХК
Гүйцэтгэх захирал



Ш.Алтанбагана

ТУЗ-ийн хараат бус гишүүн,
Стратеги, бизнес хөгжлийн хорооны
дарга
Тера Экспресс ХХК
Гүйцэтгэх захирал



ЭРХЭМ ЗОРИЛГО

Эрүүл мэндийг дэмжсэн хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчийн сэтгэл ханамжид нийцүүлэн, олон улсын стандартаар **ҮЙЛДВЭРЛЭГЧ**, **ЭКСПОРТЛОГЧ**, дотоодын зах зээлд **ТЭРГҮҮЛЭГЧ** компани байна.



АЛСЫН ХАРАА

ЭРҮҮЛ мэндийг дэмжсэн **ОРГАНИК** хүнсний бүтээгдэхүүнийг хэрэглэгчдийн өдөр тутмын хэрэглээнд хэвшүүлнэ.



ҮНЭТ ЗҮЙЛ

- Эрүүл чанартай Бүтээгдэхүүн
- Эрхэм Хэрэглэгч
- Итгэлтэй Харилцагч
- Ёс зүйтэй Бизнес
- Мэдлэг чадвартай бүтээлч Хамт олон
- Шинэ санал Санаачилга
- Монгол Оюун Сэтгэлгээнд хөрөнгө оруулагч



КОМПАНИЙН ТҮҮХЭН ТОВЧОО

2012

Монос Фарм ХХК-аас өрх тусгаарлаж, Монос Хүнс ХХК албан ёсоор үүсгэн байгуулагдав.

2013

Шилэн савлагаатай Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг үйлдвэрлэлд нэвтрүүлэв.



2014

OD00 ERP /Enterprise Resource Planing/ системийг компанийн үйл ажиллагаанд нэвтрүүлэв.

2015



ЭКОС
ЗӨӨЛӨН УС рН=8.5

Монгол Улсад анх удаа Экос рН8.5 зөөлөн шүлтлэг усыг үйлдвэрлэв.

2016



Монгол Улсад анх удаа Эко уусдаг цайг үйлдвэрлэж эхлэв.

2017



Чанарын удирдлагын тогтолцоо болох ISO9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартыг нэвтрүүлэх төслийн ажил эхлэв.

2018



БНХАУ болон Япон улсын зах зээлд бүтээгдэхүүнээ байршуулснаар албан ёсоор экспортын гараагаа эхлүүллээ.

2019



Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан IPO гаргаж нээлттэй Хувьцаат Компани болов. Олон улсын чанарын удирдлагын тогтолцоо ISO9001:2015 болон Хүнсний аюулгүй байдлын HACCP стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж Олон улсын аудитын SGS компаниар баталгаажуулж гэрчилгээгээ гардан авав

2020



Хүнсний үйлдвэрийн нэгдсэн удирдлагын тогтолцоо ISO22000:2018 болон Хүний нөөцийн менежментийн ISO:30400 стандартыг нэвтрүүлэх төслийг эхлүүлэв. Эрүүл Мэндийн Шингэн хүнсний үйлдвэрийг ашиглалтад оруулан, 8 нэр төрлийн бүтээгдэхүүнийг зах зээлд нэвтрүүлэв.

2021

Vitos брэндийн Цэнэг эрүүл мэндийн бэлдмэлийг шинэчлэн зах зээлд амжилттай байршуулав. Мөн тус брэндийн "Shot" 3 нэр төрлийн биологийн идэвхт бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн гаргалаа.

VITOS
more health



ШИНЭ БОЛОН
ШИНЭЧЛЭГДСЭН
БҮТЭЭГДЭХҮҮНҮҮД

Энхжин



Байгальд ээлтэй ЭНХЖИН | ЭРҮҮЛ МЭНДИЙН ЦАЙ савлагаагаа шинэчиллээ

Эмийн ургамалтай Энхжин эрүүл мэндийн цайны сав баглаа боодолд ашиглагдаж байгаа гялгар уутны хэрэглээг 90%, цаасны хэрэглээг 42%-аар бууруулан шинэчилсэн савлагаатайгаар худалдаанд гаргав. Ингэснээр бид жилдээ 8 тонн гялгар уут, болон цаасны хог хаягдлыг бууруулах боломжтой болсон юм.



ХАНДАЙ
ТАЙЛАГЧ

Монголын бүтээлч салбарт үнэтэй хувь нэмэр оруулагч, Монгол соёлыг дэлхийд таниулах зорилгоор ЭКОНТЭ ХХК-ийн Хандгай төсөлтэй Монос Хүнс ХК хамтран Тайлагч бүтээгдэхүүнийг шинээр худалдаанд гаргалаа. Тайлагч нь сортууруулах ундаанаас үүдэлтэй хордлогоос сэргийлж, ШАР ТАЙЛАХ үйлчилгээтэй бүтээгдэхүүн юм. Энэхүү бүтээгдэхүүний худалдан авалт бүр Монголын бүтээлч салбарт хувь нэмэр оруулах болно.

ААМИ, ТААМИ ШҮҮС ТӨРЛӨӨ НЭМЛЭЭ

“Маамуу” цуврал хүүхэлдэйн киноны гол дүрийн өхөөрдөм баатруудын нэрээр бүтээгдсэн “Аами, Таами” шүүс төрлөө нэмэн тоорын амтат Таами&Жожо, чангаанз болон лувангийн амтат Аами&Өөдөө-гөөр төрлөө нэмлээ. Энэхүү бүтээгдэхүүнийг хүүхэд багачууд өдөр тутамдаа хэрэглэснээр хоногийн С амин дэмийн хэрэгцээгээ хангаж дархлаагаа дэмжин ханиаднаас урьдчилан сэргийлэх боломжтой.



НИЙГЭМД ҮЗҮҮЛСЭН ЭЭРЭГ НӨЛӨӨ



“Томуугийн эсрэг хамтгаа” өдөрлөг

Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлгийн Нийгмийн эрүүл мэнд, хамтын ажиллагааны албанаас санаачлан Монос Хүнс ХК-ийн дэмжлэгтэйгээр “Томуугийн эсрэг хамтдаа” өдөрлөгийг зохион байгуулав. Тус арга хэмжээний үеэр Монос Хүнс компани Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж буй 600 орчим хүүхэд, асран хамгаалагчид дархлаа дэмжих нэрийн бүтээгдэхүүнийг гардуулан өгч, жүжигчилсэн тоглолт үзүүллээ. Мөн энэ үеэр СХНЭ-ийн эмч, мэргэжилтнүүд хэвтэн эмчлүүлэгчдэд гараа хэрхэн зөв угааж халдварт өвчнөөс хэрхэн сэргийлэх талаар зөвлөмж, зөвлөгөөг хүүхэд багачууддаа сонирхолтой хэлбэрээр өгсөн юм.

Маамуутай нэг өдрийг хамтгаа” өдөрлөг

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК 10 жилийн ойн хүрээнд Монгол контент ХХК-тай хамтран “Ид шидийн орон 2” хүүхэд хамгааллын төвд “Маамуутай нэг өдрийг хамтдаа” өдөрлөгийг зохион байгуулав. Энэ үеэр 200 гаруй хүүхдэд гарын бэлэг гардуулж, Аами&Таами хүүхдүүдийн хамт нэг өдрийг хөгжилтэй өнгөрүүлсэн юм.

Mongol Content



ЭКОС



Каннын кино наадамг Монгол Улсаас анх удаа оролцож буй хүүхдийн киног ивээн тэтгэлээ

Дэлхийн кино урлагийн салбарын тэргүүн зэрэглэлийн Каннын кино наадам энэ жил 75 дахь удаагаа зохион байгуулагдаж байна. Тус кино наадамд “Том толгойтын адал явдлууд” киноны уран бүтээлчид Марше ду фильм арилжааны хэсэгт хүүхдийн киногоор Монгол Улсаас анх удаа оролцож, Монос Хүнс ХК ивээн тэтгэж хамтран ажиллаа.

ТАМХИНЫ ЭСРЭГ ӨДРИЙН СУРГАЛТ


Дэлхий дахинаа жил бүрийн 05-р сарын 31-ний өдрийг “Тамхины эсрэг өдөр” болгон тэмдэглэж тамхины утаа болон хэрэглээнээс үүдэлтэй уршгийг таниулах, эдийн засагт үзүүлэх хор нөлөөллийн мэдээллийг түгээх зорилгоор тэмдэглэдэг. Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэгтэй хамтран “Тамхины хор уршиг” сэдвийн хүрээнд сургалт хийлээ. Сургалтаар тамхины хэрэглээ, утаанаас үүдэлтэй хор хөнөөл болон тамхинаас ялгардаг бодисын хор хөнөөлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө мэдээллийг хүргэв.



“Зүрхээ хайрляя” өдөрлөг

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК-ийн зүгээс нийгэмд тулгамдаад буй өвчлөлийг бууруулахад дэм болох үүднээс жил бүр тухайлсан сургалт арга хэмжээг зохион байгуулдаг. Энэ жилийн арга хэмжээгээ “Зүрхээ хайрляя” нэрийн дор СХНЭ-ийн Хүний их эмч Э.Өнөржаргалтай хамтран 2022.06.02-ны өдөр зохион байгууллаа.

2022 оны хагас жилийн онцлох үйл явдлууд



Монос Хүнс ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа амжилттай зохион байгууллаа

Монос Хүнс ХК хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаа 2022 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр Хөрөнгө оруулалтын экспогийн үеэр амжилттай зохион байгууллаа. Хурлыг ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулга даргалж, нийт саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн **79.95%** нь хуралд оролцож компанийн үйл ажиллагаатай холбоотой дараах асуудлыг хэлэлцэн батлав. Үүнд:

- Компанийн 2021 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн дүгнэлт хэлэлцэн батлах,
- Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2022 оны төсвийг батлах,
- ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох,

Монос Хүнс ХК-ийн Дотоод хяналтын лаборатори MNS ISO/IEC 17025:2018 итгэмжлэлээ гарган авлаа

Эрүүл мэндийг дэмжигч Монос Хүнс ХК-ийн Дотоод хяналтын сорилтын лаборатори нь **MNS ISO/IEC 17025:2018 буюу** "Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхид тавих ерөнхий шаардлага"-ыг хангаж Үндэсний итгэмжлэлийн төвийн даргын 2022 оны А/29 дүгээр тушаалаар магадлан итгэмжлэгдлээ. Энэхүү итгэмжлэл нь лабораторийн чанарын менежментийн тогтолцоо, техникийн чадавхи, шударга байдал, тууштай үйл ажиллагаа явуулах ерөнхий шаардлагыг тодорхойлдог байна.



Монос Групп Монгол Улсын Их Сургуулийн "ШИЛДЭГ ТҮНШ"-ээр тодорлоо

МУИС-ийн сургалт, судалгааны үйл ажиллагааны чиглэлд тогтвортой, найдвартай хамтран ажиллагч нартаа олгодог "ШИЛДЭГ ТҮНШ" байгууллагаар Монос групп шалгарлаа. Эрдэм шинжилгээ, судалгааны чиглэлд гадаад, дотоодын тэргүүлэх их дээд сургуулиудтай Монос групп нь тогтмол хамтран ажилладаг бөгөөд МУИС-тай 2011 оноос хамтран ажиллаж эхэлсэн. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд Монос групп болон МУИС-ийн эрдэмтэн докторууд таван жилийн судалгаа шинжилгээний үр дүнд монголчуудын уламжлалт хэрэглээг орчин үеийн шинжлэх ухаантай хослуулан биеийг хоргүйжүүлэх, антиоксидант үйлдэлтэй "100 наслаарай" цайг 2015 онд зах зээлд амжилттай нэвтрүүлсэн юм.


Монос Хүнс ХК ТУЗ-ийн шинэ бүрэлдэхүүнтэйгээр 2022 оны анхдугаар хурлаа хийлээ

Монос Хүнс ХК-ийн энэ оны I улирлын ТУЗ-ийн ээлжит хурал 2022.05.04 нд амжилттай болж өндөрлөлөө. Хуралд ТУЗ-ийн гишүүд танхимгаар бүрэн бүрэлдэхүүнээр 100%-ийн ирцтэйгээр хуралдаа оролцлоо. Энэ удаагийн ээлжит хурал шинэ бүтэц бүрэлдэхүүнтэйгээр хуралдаж ТУЗ-ийн дарга болон ТУЗ-ийн дэргэдэх хороо, нарийн бичгийн дарга нарыг сонгов. Хурлаар тус компанийн 1-р улирлын үйл ажиллагаа, санхүүгийн тайлан, Монос Хүнс ХК-ийн урт хугацааны болон богино хугацааны бизнес төлөвлөгөөний зорилтыг хэлэлцэн батлав.




ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД:


Борлуулалтын орлого
/сая.төг/




Нийт ашиг
/сая.төг/




Цэвэр ашиг
/сая.төг/




ЕБИТДА
/сая.төг/




Нийт ашгийн маржин



Цэвэр ашгийн маржин




ЕБИТДА маржин



ХУВЬЦААНЫ МЭДЭЭЛЭЛ

Тайлант хугацаанд Монголын Хөрөнгийн Биржид арилжаалагдсан тоо ширхэгээр 2-т, үнийн дүнгээр 6-т эрэмблэгдсэн байна.




Хамгийн дээд ханш: **149.7₮**

Хамгийн доод ханш: **98.4сая₮**

Нийт арилжаалагдсан тоо ширхэг: **20.7сая/ш**

Нийт арилжааны дүн: **2,561сая₮**

НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ /САЯ₮/



“Монос хүнс” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн №27/02 тоот тогтоолоор 2021 оны цэвэр ашгаас нийт 817,700,856 төгрөг буюу нэгж хувьцаанд 2 төгрөгийг хувьцаа эзэмшигчиддээ ногдол ашиг болгон тараахаар шийдвэрлэсэн байна.

Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр болох 2022.03.31-ний өдрөөр тогтоож, ногдол ашгийг 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн “ҮЦТХТ” ТӨХХК-иар дамжуулан хувьцаа эзэмшигчдийн дансанд байршуулахаар шийдвэрлэсэн байна.

1 2022 оны 9 дүгээр сарын 1-ний өдөр “ҮЦТХТ” ТӨХХК-ийн дансанд ногдол ашиг байршина.

2 “ҮЦТХТ” ТӨХХК Монгол Хөрөнгийн Биржид бүртгэлтэй үнэт цаасны компаниуд дээрх хувьцаа эзэмшигчдийн данс руу шилжүүлэг хийнэ

3 Хувьцаа эзэмшигч өөрийн үнэт цаасны компанид хандаж ногдол ашгаа авна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАН МЭДЭЭЛЭЛ

Үзүүлэлт /сая.төг/

2021.12.31

2022.06.30

ХӨРӨНГӨ	22,996.0	26,461.5
Эргэлтийн хөрөнгө	9,818.0	13,759.0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	258.0	106.5
Дансны авлага	2,880.0	3,731.3
Татвар, НДШ - ийн авлага	73.1	48.1
Бусад авлага	49.7	61.0
Бараа материал	5,785.6	6,313.9
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	771.5	3,498.2
Эргэлтийн бус хөрөнгө	13,178.0	12,702.5
Үндсэн хөрөнгө	12,501.3	12,060.6
Биет бус хөрөнгө	591.0	556.2
Хойшлогдсон татварын хөрөнгө	55.1	55.1
Бусад эргэлтийн бус хөрөнгө	30.6	30.6
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	22,996.0	26,461.5
Өр төлбөр	8,075.0	10,846.1
Богино хугацаат өр төлбөр	4,651.3	5,089.0
Дансны өглөг	798.4	1,101.6
Цалингийн өглөг	56.1	56.1
Татварын өр	509.0	793.7
НДШ-ийн өглөг	16.3	60.7
Богино хугацаат зээл	2,676.1	1,788.6
Зээлийн хүүгийн өглөг	20.8	33.2
Ногдол ашгийн өглөг	0.0	817.7
Урьдчилж орсон орлого	27.8	42.3
Нөөц өр төлбөр	153.7	153.7
Бусад богино хугацаат өр төлбөр	393.1	241.4
Урт хугацаат өр төлбөр	3,423.7	5,757.1
Урт хугацаат зээл	3,294.1	5,757.1
Бусад урт хугацаат өр төлбөр	129.6	0.0
Эздийн өмч	14,921.0	15,615.4
Өмч - Хувьцаат	2,318.2	2,318.2
Нэмж төлөгдсөн капитал	6,835.7	6,835.7
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	451.9	451.9
Хуримтлагдсан ашиг	5,315.2	6,009.5

САНХҮҮГИЙН ТАЙЛАН МЭДЭЭЛЭЛ

Орлого үр дүнгийн тайлан

Үзүүлэлт /сая.төг/	2021.06.30	2022.06.30
Борлуулалтын орлого (цэвэр)	7,485.3	13,879.6
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	4,103.6	7,840.6
Нийт ашиг (алдагдал)	3,381.6	6,039.0
Бусад орлого	69.5	22.7
Борлуулалт, маркетингийн зардал	1,729.8	2,746.9
Ерөнхий ба удирдлагын зардал	678.0	1,154.8
Санхүүгийн зардал	288.1	359.7
Бусад зардал	120.3	41.7
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	-8.8	-57.9
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	626.1	1,700.6
Орлогын албан татвар	74.7	188.6
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	551.4	1,512.1

Санхүүгийн харьцаа үзүүлэлтүүг

2021.06.30 2022.06.30

Төлбөрийн чадварын шинжилгээ / Liquidity Ratios

Эргэлтийн харьцаа / Current Ratio	1.2	2.7
Түргэн хөрвөх харьцаа / Quick Ratio	0.7	1.5

Санхүүгийн тогтвортой байдлын шинжилгээ / Leverage Ratios

Бие даалтын коэффициент / Shareholder Equity ratio	68%	59%
Өрийн харьцаа / Debt ratio	32%	41%
Өр эзний өмчийн харьцаа / Debt-to-Equity	48%	69%
Хөшүүргийн харьцаа/ Debt-to-EBITDA	1.68	1.43

Ашигт ажиллагааны шинжилгээ / Profitability ratios

Нийт ашгийн хувь / Gross profit margin	45.2%	43.5%
ХТЭХӨАшгийн хувь / EBITDA margin	17.5%	19.0%
Цэвэр ашгийн хувь / Net income margin	7.4%	10.9%
Нийт хөрөнгийн өгөөж / Return on Assets - ROA	2.8%	5.7%
Өөрийн хөрөнгийн өгөөж / Return on Equity - ROE	4.1%	9.7%

ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС БА УДИРДЛАГА



Монос Хүнс ХК нь эрсдэлийн удирдлагыг бүтэц зохион байгуулалтын дагуу ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хороо, Удирдлага болон Эрсдэлийн багуудаар дамжуулан хэрэгжүүлж байна. Мөн жилд хоёр удаа "Retreat" арга хэмжээг дотооддоо тогтмол зохион байгуулдаг. Уг арга хэмжээгээр компанийн дотоод болон гадаад хүчин зүйлүүдэд үндэслэн учирч болох эрсдэл болон учруулж болох сөрөг нөлөөг тодорхойлох, үнэлэх үйл ажиллагааг хийдэг. Ийнхүү болзошгүй эрсдэлүүдээ тодорхойлж тэдгээрийг үнэлснээр эрсдэлээс зайлсхийх, эрсдэл учирсан тохиолдолд авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ зэргийг тодорхойлж, Эрсдэлийн багийн үйл ажиллагаанд нэвтрүүлдэг бөгөөд сар бүрийн давтамжтай хуралдаж хянаж ажиллаж байна.

2022 оны эрсдэлийг 2021 оны Retreat арга хэмжээгээр гоорх байгалаар ангилан тогдорхойлсон. Үүнг:

- Чанарын эрсдэл
- Хүний нөөцийн эрсдэл
- Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны эрсдэл
- Үйл ажиллагааны эрсдэл
- Санхүүгийн эрсдэл
- Гадаад хүчин зүйлийн эрсдэл
- Борлуулалт маркетингийн үйл ажиллагааны эрсдэл
- Бусад эрсдэл гэж ерөнхийлөн ангилж тус бүр дээр нарийвчлан задалж төлөвлөсөн.

2022 оны эхний хагсад дараах эрсдэлүүдийг чухалчилж авч үзэн хариу арга хэмжээ авч ажиллаж байна. Түүхий эд, материалын олдоц хил гаалийн тааварлашгүй байдалтай холбоотой бараа бүтээгдэхүүний тасалдал үүсэх эрсдэл

Ковид 19 цар тахлын дэгдэлтээс улбаатай хил гааль, улс хоорондын тээврийн үйл ажиллагаа хүндэрч тааварлашгүй нөхцөл байдлууд үүссээр байна. Энэхүү эрсдэлийг бид Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа, Гадаад хүчин зүйлийн эрсдэл гэж тодорхойлон түүхий эд, материал, сав баглаа боодлын нөөц бүрдүүлэх татан авалтыг улирал тутмаар хийдэг байсан бол хагас жилийн нөөц татан авалт хийх замаар эрсдэлээ бууруулж байна. Хүний нөөцийн хомсдол үүсэх эрсдэл

Аж ахуйн нэгжүүдэд тулгараад буй томоохон хүндрэлүүдийн нэг болох хүний нөөцийн хомсдолыг бид томоохон эрсдэлүүдийн нэг гэж үзэн "Хөдөлмөр эрхлэлтийн тогтвортой байдал" сэдвийн хүрээнд 2022 оны хагас жилийн "Retreat" арга хэмжээгээ зохион байгуулсан. Энэхүү арга хэмжээгээр тус эрсдэлийн хүрээнд Хүний нөөцийн бүрдүүлэлт, Тогтвортой ажил эрхлэлт гэсэн 2 хэсэгт хуваан авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны жагсаалт гаргаж түүний дагуу ажиллаж эхлээд байна.

RETREAT 2021





Эрүүл мэндийг дэмжсэн органик хүнсний бүтээгдэхүүнийг өдөр тутмын амьдралд хэвшүүлэх алсын хараатай Монос Хүнс ХК нь 2019 онд анх удаагаа IPO буюу олон нийтэд хувьцаагаа нээлттэйгээр арилжаалж 2020 онд Олон улсын GMP, ISO-9001:2015, HACCP стандартын шаардлагыг бүрэн хангасан "Эрүүл мэндийн шингэн хүнсний үйлдвэр"-ээ ашиглалтад оруулсан билээ. Эрүүл аюулгүй чанартай бүтээгдэхүүнийг Монголынхоо ард түмэнд бахархалтайгаар үйлдвэрлэж, хэрэглэгчдийн хэдийнээ ташаал болоод буй Экос зөөлөн шүлтлэг ус, "Vitos" брэндийн Цэнэг эрүүл мэндийн бэлдмэл бүтээгдэхүүнүүдээ шинэчлэн гаргаад байна. Мөн 2021 онд "Vitos" брэндийн биологийн идэвхт 3 нэр төрөл Шот бүтээгдэхүүнээ зах зээлд амжилттай байршууллаа.

Тус компани нь Хуурай болон шингэн хүнсний үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж ирсэн. Энэ жил Монос Хүнс ХК-ийн 10 жилийн ой тохиож байгаа бөгөөд энэхүү түүхэн мөчид бизнесийн ирээдүйгээ тодорхойлох, хөгжлийн дараагийн үе шатад хөтлөх, хоёр үйлдвэрээ нэгтгэх үйлдвэрлэлийн "MFC 2.0" төслөө эхлүүлэх болсноо нийт хувьцаа эзэмшигч, хэрэглэгчид та бүхэндээ дуулгахад таатай байна.



MFC 2.0 Төслийн боломж болон давуу талууд:

- Үйлдвэрийн автоматжуулалт
- Үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж халуун, хүйтэн савлагаа болон биологийн идэвхт бүтээгдэхүүний савлагааг нэгэн зэрэг үйлдвэрлэх
- Үйлдвэр-оффисын хосолмол шийдлийг бий болгох ажилтнуудын сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх
- Үйл ажиллагаа өргөжиж, борлуулалтын орлого нэмэгдэх
- Шинэ брэнд бүтээгдэхүүнүүдээ зах зээлд амжилттай үйлдвэрлэн гаргах юм.



ТӨВ ОФФИС:

Монгол улс, Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
2-р хороо, Чингисийн өргөн чөлөө 205/2 тоот, 17043

ШИНГЭН ХҮНСНИЙ ҮЙЛДВЭР:

Монгол улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс
Сонголонгийн зам 32/3 тоот, 16103



www.monosfoods.mn



foods@monos.mn



MonosFoods



976-7777-3525